

Гэрчүүд

Гэрч #1

Их Эзэний үгс

Иосеф Смитэд алтан ялтаснуудыг дэлхийд бүү үзүүл хэмээн зарлигласан (Сургаал ба Гэрээ 5:3-ыг үзнэ үү). Сургаал ба Гэрээ 5:6–10-ыг уншаад, Иосефт юуг хуваалцаж болно гэж зөвшөөрснийг олж мэд.

Та 5, 6, 7-р шүлэгт Их Эзэний давтан хэлсэн үг хэллэгүүдийг тэмдэглэн авч болох юм.

- Их Эзэн яагаад биднийг ялтаснууд үнэхээр байсан гэдгийг мэдэхийн оронд Мормоны Номон дахь Түүний үгсэд итгэж, сонсоосой хэмээн хүсдэг гэж та бодож байна вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) Мормоны Номын талаар ийн заасан.



Нотолгоо шаардах дуртай дэлхийд хэдийгээр зарим хүнд тустай байж болох ч үүний үнэний нотолгоо нь археологи эсвэл антропологид тулгуурладаггүй. Мөн батлахад тустай байх боловч үүний үнэн байдал нь үгийн судалгаа эсвэл түүхийн дүн шинжилгээнд оршдоггүй. Үүний үнэнийг шалгах шалгалт нь үүнийг уншихаас хамаардаг. Энэ бол Бурханы ном. (Gordon B. Hinckley, "Four Cornerstones of Faith," *Ensign*, Feb. 2004, 6)

Мормоны Номоос судлан, уг номоор заалгуулж байсан туршлагаа тунгаан бодоход хэдэн хором зарцуул. Ийн судлах нь таны амьдралд хэрхэн нөлөөлсөн талаар бод. Төрсөн зарим бодол санаагаа судлах тэмдэглэлдээ бичиж болох юм.

Гэрч #2

Гурван гэрчийн гэрчлэл

Сургаал ба Гэрээ 5:11–15-ыг уншаад, Их Эзэн эцэст нь хэнд ялтаснуудыг үзэхийг зөвшөөрөхийг олж мэд.

- Та эдгээр шүлгээс Гурван гэрчийн гэрчлэлийг хүчирхэг болгох юг олж харсан бэ?

Хожим нь Мартин Харрис, Оливер Каудери, Давид Витмер гурав алтан ялтаснуудыг харж, тэдгээр нь бодит юм гэдгийг гэрчилсэн. Сургаал ба Гэрээ 17-г судлахдаа та энэ үйл явдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдэж авна.

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Даллин Х.Өүкс Гурван гэрчийн талаар ийн заасан.



Өөр ямар ч гэрч тэдний гэрчлэлийг няцаагаагүй юм. Хэн нэгэн тэдний гэрчлэлийг үгүйсгэж болох ч асар их доромжлол болон хувийн сул дорой байдалтайгаа тэмцэлдэн байхдаа амьдралынхаа эцсийг хүртэл, хэвлэгдэж гарсан гэрчлэлдээ нэгдэж, гэрчлэлээ хадгалж үлдсэн эдгээр сайн хүний талаар хэрхэн тайлбарлах билээ? Мормоны Номтой л адил харсан зүйлээ ярьсан сайн мөн шударга эрчүүдийн чин сэтгэлийн гэрчлэл дэх тайлбараас илүү дээр тайлбар байхгүй. (Dallin H. Oaks, "The Witness: Martin Harris," *Liahona*, May 1999, 36)

Мормоны Номын эхэнд байгаа Гурван гэрчийн гэрчлэлийг уншихыг эсвэл Мормоны Ном үнэн гэдгийг танд гэрчилж байсан хүмүүсийн нэрсийг жагсаахыг бод. Тэдний гэрчлэл таныхыг хэрхэн хүчирхэгжүүлсэн талаар бод.